

# МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

---

№ 20/2

Улаанбаатар хот

Мөнгөний бодлогын хороо (МБХ) 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр ээлжит бусаар хуралдаж, хуралдааныг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн удирдав. Уг хуралдаанаар мөнгөний бодлого, макро зохистой бодлогын хүрээнд холбогдох бодлогын арга хэмжээнүүдийг авах эсэх талаар хэлэлцлээ.

МБХ-ны хуралдаанд макро эдийн засгийн өнөөгийн болон ирээдүйн төлөв, санхүүгийн зах зээл, гадаад, дотоод орчны тодорхой бус байдалд гарч буй гол өөрчлөлтүүд, Ковид-19 вирусын тархалттай холбоотой эдийн засагт үүсч болзошгүй эрсдэл, иргэдийн хэрэглээний зээлийн эргэн төлөлтөд үүсч буй хүндрэлийн талаар Монголбанкны Мөнгөний бодлогын газар (МБГ)-аас танилцууллаа.

Мөнгөний бодлогын хороо 3 дугаар сарын 11-ний өдөр хуралдаж шийдвэр гаргаснаас хойш Ковид-19 вирусын тархац эрчимжиж, эрдэс бүтээгдэхүүний үнэ болон олон улсын санхүүгийн зах зээл дээр огцом хэлбэлзлүүд бий болж гадаад орчин огцом муудаад байна. Ковид-19 вирусын тархалтын цар хүрээ, үргэлжлэх хугацаа, түүний эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээ өдрөөс өдөрт өөрчлөгдөж байгаа нь худалдааны түнш орнуудын эдийн засгийн өсөлтийг сааруулж, улмаар манай улсын гадаад эрэлт, гадаад худалдааны төлөвийн тодорхой бус байдлыг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлж байгааг онцлов.

Инфляци энэ онд өмнөх төсөөллөөс бууран оны эцэст 6.2 хувьд хүрэх төсөөлөлтэй байна. Үүнд: 1) дэлхийн зах зээл дэх газрын тосны үнэ огцом унасантай холбоотойгоор дотоодын шатахууны үнэ хямдрах, 2) Ковид-19 вирусын нөлөөгөөр гадаад, дотоод эдийн засгийн идэвхжил өмнөх төсөөллөөс муудаж байгаа нь голлон нөлөөлөхөөр байна. Ирэх онд эдийн засаг тогтворжиж дотоод эрэлт сэргэх, газрын тосны үнэ алгуур өсч шатахууны үнэ нэмэгдэх зэрэг нөлөөгөөр инфляци бага зэрэг нэмэгдэхээр байгааг танилцууллаа.

Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл хүлээлтээс муудаж байгааг МБГ-ын зүгээс онцоллоо. Энд Ковид-19 вирусын тархалт даамжирч эдийн засагт үзүүлэх нөлөө өмнөх төсөөллөөс удаан үргэлжлэх, эдийн засгийн зарим салбарын холбогдох үзүүлэлтүүд хүлээлтээс доогуур гарсан нь голлон нөлөөлсөн байна.

Тухайлбал, уул уурхайн салбарын голлох 5 бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2020 эхний 2 сард 26.1 хувиар, боловсруулах аж үйлдвэр 1.8 хувиар агшаад байна. Мөн нэгдүгээр улиралд нүүрс, зэс, алт, боловсруулаагүй нефтийн экспортын орлого буурснаар нийт экспорт 42 хувиар агшсан бөгөөд энэ нь уул уурхайн салбарын өсөлтөд сөрөг нөлөө үзүүлнэ. Төсөөллөөр эдийн засаг энэ оны эхний хагаст огцом хумигдаж, сүүлийн хагаст сэргэх хүлээлттэй байна. Уул уурхайн салбарын өсөлт саарахад гадаад эрэлт муудах, ариутгал халдваргүйжүүлэлт хийх журмын хэрэгжилттэй холбоотойгоор нүүрсний экспорт тасалдах, газрын тосны экспорт эхлэх хугацаа тодорхойгүй байгаа зэрэг нь нөлөөлөхөөр байгаа бол уул уурхайн бус салбарын хувьд вирусын эсрэг авч хэрэгжүүлж байгаа нийтийг хамарсан хорио цээрийн арга хэмжээтэй холбоотойгоор боловсруулах, үйлчилгээ, тээврийн салбар, татвар бүрдүүлэлт огцом саарахаар байна. Мөн ажилгүйдлийн түвшин нэмэгдэж, ажил эрхлэлт буурч байгааг онцлов.

Төсвийн төлөв муудах, тэр дундаа төсвийн орлого тасрах эрсдэл нэмэгдэж байгааг танилцууллаа. Төсвийн нийт орлого энэ оны эхний 2 сард өмнөх оны мөн үеэс 174 тэрбум төгрөгөөр бага гарсан бол төсвийн нийт зардал өмнөх оны мөн үеэс 29.2 хувиар нэмэгдэв. Цаашид эдийн засгийн өсөлт саарах, гадаад худалдааны эргэлт муудах, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ буурах, хорио, цээрийн дэглэм үргэлжлэх, татварын хөнгөлөлт зэргээс шалтгаалан төсвийн орлого энэ онд өмнөх оноос буурахаар байна.

Эдийн засгийн идэвхжил буурч байгаагаас шалтгаалан банкны системийн зээлийн өсөлт үргэлжлэн саарч, гадаад валютын хадгаламж нэмэгдэж буйг танилцууллаа. Тодруулбал, хэрэглээний зориулалттай зээлийн өсөлт сөрөг түвшинд хадгалагдаж байгаа бөгөөд тэтгэврийн зээл тэглэсэн арга хэмжээний нөлөөг хасч тооцвол иргэдийн хэрэглээний зээлийн үлдэгдэл 2020 оны 2 дугаар сард жилийн 6.3 хувиар буураад байна. Бизнесийн зориулалттай зээлийн өсөлт 9.6 хувьд хүрч саарсан бөгөөд том аж ахуй нэгжүүдийн төгрөгийн зээлийн өсөлт харьцангуй тогтвортой байгаа боловч дийлэнх нь жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд олгох зээлийн дүн буурсантай холбоотой байна. Түүнчлэн, гадаад валютын зээл өмнөх оны 2 дугаар сараас 27.8 хувиар буураад байна.

Гадаад худалдааны алдагдал тэлж, төлбөрийн тэнцлийн төсөөлөл энэ онд өмнөх төсөөллөөс муудахаар байна. Төлбөрийн тэнцлийн төсөөлөл муудахад;

- 1) Ковид-19 вирусын дэгдэлтээс сэргийлэх бодлогын хүрээнд нүүрсний экспорт оны эхний хагасын туршид удааширч, бага байх
- 2) Дэлхийн эдийн

засгийн идэвхижил суларч түүхий эдийн эрэлт буурахаар байгаа нь зэс, газрын тосны үнийг бууруулах 3) Монгол Улс Ковид-19 вирусын тархалтаас сэргийлэн, олон улсын агаарын нислэгүүдийг энэ оны 2-р сараас хойш зогсоосны зэрэгцээ бусад орнуудад уг вирусын дэгдэлт нэмэгдэж байгаа нь ирэх улирлуудад аялал жуулчлалын үйлчилгээний орлогыг бууруулах зэрэг нь нөлөөлөхөөр байна.

Танилцуулгын төгсгөлд нийтийг хамарсан хорио цээрийн дэглэмээс шалтгаалсан эдийн засгийн хүндрэлтэй холбоотойгоор иргэдийн орлого буурч, хэрэглээний зээлийн эргэн төлөлт саатах эрсдэл бий болж байгаа тул санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангахын тулд зээлийн эргэн төлөлтийг зээлдэгчийн санхүүгийн чадавхитай уялдуулах шаардлага үүсч байна. Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлснээр зээлдэгчдийн зээлийн сарын төлбөрийн дарамт буурах буюу гар дээр үлдэх орлого нэмэгдсэнээр хувийн хэрэглээг урамшуулж, зээл чанаргүйдэх эрсдэлийг бууруулна.

Түүнчлэн хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааны аргачлалыг шинэчилснээр зээлийн нөхцөл илүү уян хатан болно. Одоогийн “Өр, орлогын харьцаа тооцох аргачлал”-аар өрхийн гишүүд хамтран хэрэглээний зээл авах тохиолдолд өр, орлогын харьцааг тооцоход зөвхөн үндсэн зээлдэгчийн орлогыг ашигладаг. Өөрөөр хэлбэл, өмнө нь хамтран зээлдэгчийн үүрэг хүлээж ипотекийн зээл эсвэл өөр төрлийн өндөр дүнтэй зээл авсан иргэд хэрэглээний зээл авах үед зээлийн сарын төлбөр өндөр тооцоологдож, зээл авах боломжийг хязгаарлаж байна. Иймд өр, орлогын харьцааны тооцоололд үндсэн болон хамтран зээлдэгчдийн орлогыг хамруулах байдлаар “Өр, орлогын харьцааг тооцох аргачлал”-д холбогдох өөрчлөлтийг оруулахаар төлөвлөж байгаагаа танилцууллаа.

Мөнгөний бодлогын газрын зүгээс бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж 9 хувьд хүргэх, Макро зохистой бодлогын хүрээнд; 1) Эргэн төлөлтийн хүндрэлд орсон зээлдэгчдийн хувьд хэрэглээний зээлийн үлдэгдэл хугацааг нэг удаа 12 хүртэлх сараар сунгахыг зөвшөөрөх; 2) Хэрэглээний зээлийн өр, орлогын харьцаа тооцох аргачлалыг шинэчилж, өрхийн орлогыг ашиглан ӨОХ-г тооцох боломжийг бүрдүүлэх санал гаргасныг МБХ-ны гишүүд хэлэлцлээ.

Мөнгөний бодлогын хорооны гишүүд эдийн засаг, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв болон гадаад, дотоод орчны тодорхой бус байдал, эрсдэлийг харгалзан үзээд эдийн засгийн идэвхжилийг дэмжих зорилгоор бодлогын хүүг бууруулахын зэрэгцээ хүндрэлд орсон зээлдэгчийн

хэрэглээний зээлийн хугацааг 12 сар хүртэлх хугацаагаар 1 удаа сунгаж зээлийн сарын эргэн төлөлтийн хэмжээг бууруулах бодлогын багц шийдвэрийг гаргах нь зүйтэй гэж үзэв.

Мөн Мөнгөний бодлогын хороо хуралдахаас өмнө бодлогын хүүний шийдвэр гарсан мэтээр олон нийтэд зарласан нь Төв банкны хараат бус байдалтай харшиж байгааг МБХ-ны гишүүд онцлов.

Мөнгөний бодлогын хорооны зарим гишүүд эдийн засаг богино хугацаанд хэвийн түвшиндээ орно гэж хэлэхэд эрт байгаа учраас дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийн төсөөлөл илүү ихээр муудах эрсдэлтэй болохыг анхааруулсан. Мөн ханшийн эрсдэл өндөр байгаа ч эдийн засгийн өсөлтийг дэмжих нь нэн тэргүүнд хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээ гэдэгтэй санал нийлэв.

Ийнхүү, Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 4 дүгээр сарын 13-ны ээлжит хуралдаанд нийт 5 гишүүн оролцож бодлогын саналыг МБХ-ны гишүүд 100 хувь дэмжив.

### **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн ээлжит хурлаар бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 9 хувьд хүргэх, эргэн төлөлт нь хүндрэлд орсон зээлдэгчийн хэрэглээний зээлийн хугацааг 12 хүртэлх сараар сунгах шийдвэр гаргалаа.